



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/057/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.21 № 45

танай _____-ны № _____-т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАТВАРЫН
ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Татвар төлөгчдийн татварын боловсролыг дээшлүүлэх, сургалт сурталчилгаа хийх, татвар төлөгчдийн өдрөөр зохион байгуулсан арга хэмжээний шагнал, сумдад ажиллах шатахуун бусад үйл ажиллагааны зардалд 22,000.0 мянган төгрөг, Увс аймагт зохион байгуулагдсан татварын улсын байцаагчдын мэргэшүүлэх сургалтын замын зардал 3,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус шийдвэрлэж өгсөн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолоор Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 10.0 хувиар олгохоор шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу олгох орон нутгийн нэмэгдэл 12,471.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс дутуу олгосон байна.

8225020115

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 672,903.0 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгодог болсонтой холбоотой байна.

Татварын ерөнхий газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 86,625.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон бөгөөд 67,597.8 мянган төгрөгийг албан хаагчдад 12 дугаар сард урамшуулал олгоход зарцуулсан байна.

Тайлант онд Татварын ерөнхий газраас 15,099.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 3 зорилт 42 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 41 арга хэмжээг 100.0 хувь, 1 арга хэмжээг 70.0 хувьтай хэрэгжүүлж биелэлтийг 99.2 хувьтай хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,121,999.75	170,805,555.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,013,147.81	51,976,747.81
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	34,013,147.81	51,976,747.81
31110	Төгрөг	34,013,147.81	51,976,747.81
335	Бусад авлага	-	431,387.60
3351	Байгууллагаас авах авлага	-	431,387.60
35	БАРАА МАТЕРИАЛ	130,108,851.94	118,397,419.84
354	Хангамжийн материал	130,108,851.94	118,397,419.84
35410	Бичиг хэргийн материал	105,527,039.34	99,157,321.24
35420	Аж ахуйн материал	14,506,530.60	13,835,323.60
35430	Сэлбэг хэрэгсэл	2,439,000.00	600,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,636,282.00	4,804,775.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	604,467,508.54	555,181,575.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	604,467,508.54	555,181,575.03
392	Биет хөрөнгө	539,247,508.54	489,961,575.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	471,761,431.33	471,761,431.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(61,375,478.17)	(71,065,163.47)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,000,000.00	120,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,598,153.20)	(77,621,150.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	237,635,084.16	252,734,084.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(163,924,442.56)	(206,075,088.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,108,433.95	32,108,433.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,359,366.97)	(31,880,971.25)
393	Биет бус хөрөнгө	65,220,000.00	65,220,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	65,220,000.00	65,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	768,589,508.29	725,987,130.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	406,988.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	406,988.05
413	Өглөг	-	985,208,095.81
4136	Бусад өглөг	-	406,988.05
41361	Байгууллагад төлөх өглөг	-	406,988.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	768,589,508.29	725,580,142.23
51	Засгийн газрын хувь оролцоо	768,589,508.29	725,580,142.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	583,511,152.93	583,511,152.93
51101	Өмч: - төрийн	583,511,152.93	583,511,152.93
512	Хуримтлагдсан үр дүн	77,958,058.69	34,948,692.63
51210	Өмнөх үеийн үр дүн	107,538,092.91	77,958,058.69
51220	Тайлант үеийн үр дүн	(29,580,034.22)	(43,009,366.06)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,120,296.67	107,120,296.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	768,589,508.29	725,987,130.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,593,516,955.60	2,332,181,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,527,219.60	62,207,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,527,219.60	62,207,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,854,353.60	15,207,000.00

120009	Бусад орлого	34,012,866.00	47,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,548,989,736.00	2,269,974,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,525,657,400.00	2,198,560,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,525,657,400.00	2,198,560,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,033,500.00	71,414,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,298,836.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,298,836.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,623,096,989.82	2,375,190,966.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,623,096,989.82	2,375,190,966.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,582,917,804.05	2,158,747,878.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,205,983,155.71	1,670,274,254.66
210101	Үндсэн цалин	578,983,013.51	719,577,358.07
210102	Нэмэгдэл	299,618,740.00	488,021,092.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,223,267.98	64,886,819.23
210104	Урамшуулал	264,158,134.22	397,788,985.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,012,916.12	200,320,954.63
210201	Тэтгэврийн даатгал	100,955,531.90	140,216,804.48
210202	Тэтгэмжийн даатгал	11,865,115.84	16,430,078.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,434,253.14	8,128,128.91
210204	Ажилгүйдлийн даатгал	2,061,630.10	7,098,522.55
210205	Эрүүл мэндийн даатгал	20,696,385.65	28,447,419.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,371,179.88	32,000,796.23
210301	Гэрэл, цахилгаан	28,615,823.88	28,501,740.23
210303	Цэвэр, бохир ус	3,755,356.00	3,499,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,156,527.73	35,145,826.50
210401	Бичиг хэрэг	8,902,594.73	5,466,990.00
210402	Тээвэр, шатахуун	5,199,829.00	8,696,794.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,703,080.00	6,006,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,111,024.00	1,929,800.00
210408	Бараа материал акталсны зардал	-	12,806,142.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,238,060.00	9,330,950.00
210604	Урсгал засвар	10,238,060.00	9,330,950.00
2107	Томилолт, зочны зардал	5,358,000.00	17,949,350.00
210702	Дотоод албан томилолт	5,358,000.00	17,949,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,644,729.52	97,340,813.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,469,786.52	96,123,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	597,475.00	714,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,108.00	178,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	339,360.00	280,921.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,153,235.09	96,384,933.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,033,500.00	27,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	5,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,119,735.09	64,384,933.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,179,185.77	216,443,087.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,836,036.00	183,268,034.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,298,836.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	151,591,634.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,537,200.00	31,676,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,343,149.77	33,175,053.53

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,343,149.77	33,175,053.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(29,580,034.22)	(43,009,366.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(29,580,034.22)	(43,009,366.06)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,583,662,602.00	2,318,144,186.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,672,866.00	48,169,586.40
120	Нийтлэг татварын бус орлого	34,672,866.00	48,169,586.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,672,866.00	48,169,586.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	-
120009	Бусад орлого	34,012,866.00	48,169,586.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,848,989,736.00	2,269,974,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,525,657,400.00	2,198,560,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,525,657,400.00	2,198,560,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,033,500.00	71,414,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,033,500.00	71,414,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,298,836.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,298,836.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,568,837,936.00	2,300,180,586.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,568,837,936.00	2,300,180,586.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,528,658,750.23	2,083,737,498.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,205,983,155.71	1,671,425,102.32
210101	Үндсэн цалин	578,983,013.51	719,577,358.07
210102	Нэмэгдэл	299,618,740.00	488,021,092.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,223,267.98	64,886,819.23
210104	Урамшуулал	264,158,134.22	398,939,832.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,012,916.12	200,364,092.92
210201	Тэтгэврийн даатгал	100,955,531.39	140,259,942.77
210202	Тэтгэмжийн даатгал	11,865,115.84	16,430,078.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,434,253.14	8,128,128.91
210204	Ажилгүйдлийн даатгал	2,061,630.10	7,098,522.55
210205	Эрүүл мэндийн даатгал	20,696,385.65	28,447,419.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,371,179.88	32,000,796.23
210301	Гэрэл, цахилгаан	28,615,823.88	28,501,740.23
210303	Цэвэр, бохир ус	3,755,356.00	3,499,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,519,809.00	24,357,394.40
210401	Бичиг хэрэг	4,379,500.00	5,014,850.00
210402	Тээвэр, шатахуун	5,199,829.00	8,696,794.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,703,080.00	6,006,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,997,400.00	4,399,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,599,460.00	8,299,950.00
210604	Урсгал засвар	10,599,460.00	8,299,950.00
2107	Томилолт, зочны зардал	5,358,000.00	17,949,350.00
210702	Дотоод албан томилолт	5,358,000.00	17,949,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,780,729.52	97,340,813.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,605,786.52	96,123,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	597,475.00	714,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,108.00	178,592.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	339,360.00	280,921.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,033,500.00	32,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,033,000.00	27,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,179,185.77	216,443,087.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,836,036.00	183,268,034.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,298,836.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	151,591,634.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,537,200.00	31,676,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,343,149.77	33,175,053.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,343,149.77	33,175,053.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,824,666.00	17,963,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,599,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,599,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	3,599,000.00	-
223001	Бусад хөрөнгө	3,599,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,599,000.00)	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,225,666.00	17,963,600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,787,481.81	34,013,147.81
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,013,147.81	51,976,747.81

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	107,538,092.91	798,169,542.51
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	77,958,058.69	768,589,508.29
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,009,366.06)	(43,009,366.06)
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	34,948,692.63	725,580,142.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,198,560,400.0	2,165,385,346.47	33,175,053.53	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,198,560,400.0	2,165,385,346.5	33,175,053.5	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,044,328,700.0	2,011,153,712.47	33,174,987.5	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,655,977,500.0	1,636,927,429.92	19,050,070.1	98.8
21010 1	Үндсэн цалин	674,832,800.0	718,407,771.67	(43,574,971.7)	106.5
21010 2	Нэмэгдэл	453,506,100.0	454,693,006.31	(1,186,906.3)	100.3
21010 3	Унаа хоолны хөнгөлөлт	78,314,800.0	64,886,819.23	13,427,980.8	82.9
21010 4	Урамшуулал	449,323,800.0	398,939,832.71	50,383,967.3	88.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,997,300.0	196,277,978.92	10,719,321.1	94.8
21020 1	Тэтгэврийн даатгал	143,838,200.0	136,173,828.77	7,664,371.2	94.7
21020 2	Тэтгэмжийн даатгал	15,789,800.0	16,430,078.71	(640,278.7)	104.1
21020 3	ҮОМШӨ-ний даатгал	7,894,900.0	8,128,128.91	(233,228.9)	103.0
21020 4	Ажилгүйдлийн даатгал	7,894,900.0	7,098,522.55	796,377.5	89.9
21020 5	Эрүүл мэндийн даатгал	31,579,500.0	28,447,419.98	3,132,080.0	90.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,988,200.0	32,000,796.23	2,987,403.8	91.5
21030 1	Гэрэл, цахилгаан	30,988,200.0	28,501,740.23	2,486,459.8	92.0
21030 3	Цэвэр, бохир ус	4,000,000.0	3,499,056.00	500,944.0	87.5
2104	Хангамж, бараа материалын зардал	24,725,000.0	24,357,394.40	367,605.6	98.5
21040 1	Бичиг хэрэг	5,015,000.0	5,014,850.00	150.0	100.0
21040 2	Тээвэр, шатахуун	8,700,000.0	8,696,794.40	3,205.6	100.0
21040 3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,350,000.0	6,006,100.00	343,900.0	94.6
21040 5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.0	240,000.00	20,000.0	92.3
21040 6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,400,000.0	4,399,650.00	350.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,300,000.0	8,299,950.00	50.0	100.0
21060 4	Урсгал засвар	8,300,000.0	8,299,950.00	50.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	17,950,000.0	17,949,350.00	650.0	100.0
21070 2	Дотоод албан томилолт	17,950,000.0	17,949,350.00	650.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	90,390,700.0	90,340,813.00	49,887.0	99.9

	үйлчилгээний төлбөр, хураамж				
21080 1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,123,000.0	89,123,000.00	-	100.0
21080 3	Даатгалын үйлчилгээ	714,300.0	714,300.00	-	100.0
21080 4	Тээврийн хэрэгслийн татвар	207,600.0	178,592.00	29,008.0	86.0
21080 5	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.00	-	100.0
21080 7	Газрын төлбөр	301,800.0	280,921.00	20,879.0	93.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.0	5,000,000.00	-	100.0
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.0	5,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,231,700.00	154,231,634.00	66.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	154,231,700.0	154,231,634.00	66.0	100.0
21320 8	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	151,591,700.0	151,591,634.00	66.0	100.0
21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.0	2,640,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,198,560,400.0	2,165,385,346.47	33,175,053.5	98.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,198,560,400.0	2,165,385,346.47	33,175,053.5	98.5
13100 1	Улсын төсвөөс санхүүжих	2,198,560,400.0	2,165,385,346.47	33,175,053.5	98.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43.0	41.0	6.0	95.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	4.0	100.0
61000 1	Төсвийн байгууллага	1.0	1.00	4.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.0	40.0	2.0	95.2
62000 1	Удирдах ажилтан	1.0	1.00	-	100.0
62000 2	Гүйцэтгэх ажилтан	37.0	35.00	2.0	94.6
62000 3	Үйлчлэх ажилтан	4.0	4.00	-	100.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 12,806.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардлыг 12,806.1 мянган төгрөгөөр дутуу, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлыг 12,806.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- **Хуулийн хэрэгжилттэй холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 142,052.1 мянган төгрөгийн 20 гүйлгээ мэдээлээгүй.

Залруулагдаагүй нийт 318.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 318.2 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Төлбөрийн акт

1. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй ажилтанд нөхөн олговрыг олгохдоо 318.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

5.3 Албан шаардлага

1. Бичиг хэргийн материал дансанд 6 нэр төрлийн 97,768.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаал, Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар, "Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: а.Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэд, бусдад түрээслүүлэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа: ба б. Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бичиг хэргийн материалын дансанд хөрөнгө бүртгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	Залруулаагүй			Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн Татварын газар	Үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардлыг 12,806.1 мянган төгрөгөөр дутуу, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлыг 12,806.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Шилэн дансны цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 142,052.1 мянган төгрөгийн 20 гүйлгээ мэдээлээгүй.	1	12,806.1	-	-	1	12,806.1	1	12,806.1	-	-	-	-
Дүн		1	12,806.1	1	-	1	12,806.1	1	12,806.1	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн Эмнэлэг	Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй ажилтанд нөхөн олговрыг олгохдоо 318.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон. Бичиг хэргийн материал дансанд 6 нэр төрлийн 97,768.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэсэн.	1	318.2	1	318.2	-	-	-	-	-	-	-
Дүн		2	318.2	1	318.2	1	-	-	-	-	-	-



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
	НИЙТ	1	1			1				

